



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 04 сарын 23 өдөр

Дугаар А/128

Сүхбаатар сум


Захирамжуудад нэмэлт өөрчлөлт оруулж, хугацаа сунгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 "а", 29.2, 29.3, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн "Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх хугацааг сунгах тухай" 104 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын хэмжээнд Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгасантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2021 оны 4 дүгээр сарын 09-ний өдрийн "Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай" А/108 дугаар захирамжийн нэг дэх хэсгийн "...4 дүгээр сарын 25-ны өдрийн 00.00 цаг хүртэл", мөн 2021 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн "Хичээл, сургалтын үйл ажиллагааг түр хугацаагаар зогсоох тухай" А/119 дүгээр захирамжийн нэг дэх хэсгийн "...2021 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийг дуустал" гэснийг тус тус "2021 оны 5 дугаар сарын 08-ны өдрийн 06.00 цаг хүртэл" гэж өөрчилсүгэй.

2. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг аймгийн Нийгмийн бодлогын асуудал хариуцсан Засаг даргын орлогч /Ц.Рэгээдмаа/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ш.ОРГИЛ